



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/254

Ховд

Газар эзэмших зөвшөөрөл олгох тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар өмчлөх эрхээсээ татгалзаж орон сууцны зориулалтаар газар эзэмших хүсэлт гаргасан дараах аж ахуй нэгж байгууллагад газрыг эзэмшүүлсүгэй.

1.1.Жаргалант сумын Магсаржав багийн 1 дүгээр гудамжны 35 тоотод байрлах 1132.0 метр квадрат газрыг “Эрдэнийн шим” ХХК /2033771/-д хаягийг Баянгол 1 дүгээр гудамжны 112 тоот болгон орон сууцны зориулалтаар 5 жилийн хугацаагаар,

1.2.Жаргалант сумын Магсаржав багийн 1 дүгээр гудамжны 34 тоот, 1 дүгээр гудамжны 20 б тоот байрлах газруудыг нэгтгэн 1894.0 метр квадрат газрыг “Бат арга билэг” ХХК /4076346/-д хаягийг Баянгол 1 дүгээр гудамжны 110 тоот болгон орон сууцны зориулалтаар 5 жилийн хугацаагаар,


1.3.Жаргалант сумын Буянт багийн Хөгжлийн-1 дүгээр гудамжны 103 тоотод байрлах 778 метр квадрат газрыг Шонтлой Дэнсмаа /ПЭ62031807/-д амины орон сууцны зориулалтаар 15 жилийн хугацаагаар,

1.4. Жаргалант сумын Магсаржав багийн 3 дугаар 60 айлын орон сууцны хойд талд байрлах, 27.0 метр квадрат газрыг Жанчивын Батсайхан /ПЮ70041775/-д авто гражны зориулалтаар 15 жилийн хугацаагаар тус тус эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Дөлбадрал/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



02 D/Zax-A/254-Da